

8 дугаар сарын байдлаарх аймгийн төсөв, санхvv

Энэ сарын байдлаар орон нутгийн төсөвт нийт 4347,1 сая тогрогийн урсгал орлого оруулахаар төлөвлөгдсөнөөс, 3186,5 сая тогрогийн орлого хуримтлагдаж, төлөвлөгөө 1170,6 сая тогроогоор буюу 26,7 хувиар дутуу биелсэн дvнтэй байна. Орон нутгийн төсөвлөгдсөн орлогын 3385,5 сая тогрогийг татварын орлого, 178,1 сая тогрогийг татварын бус орлого эзлэх ба татварын орлогоор 2284,2 сая тогрог, татварын бус орлогоор 154,9 сая тогрогийг төсөвт төвлөрvүлж, татварын төлөвлөгөөг 1043,9 тогроогоор буюу 32,5 хувиар, татварын бус орлогын төлөвлөгөө 23,2 сая тогрог буюу 13 хувиар тус тус тасалдуулжээ.

Төсвийн орлогын бүрдэлт хvндрэлтэй байгааг шийдвэрлэх зорилгоор улсын төсвөөс 783,4 сая тогрогийн санхvvгийн дэмжлэг, мөн 600,0 сая тогрогийн зээл авч, төсөв санхvvгийн вйл ажиллагааг хэвийн явуулахыг хичээж ажиллав. Орон нутгийн төсвийн нийт зарлага 4319,5 сая тогрог хvрсэн ба төлөвлөгдсөнөөс 27,6 сая тогрогийг дутуу зарцуулав.

oЭнКо компаниас тологдох орон нутгийн татварын орлого тасарч байгаагаас шалтгаалан сумдад олгох санхvvгийн дэмжлэгийг бүрэн олгож чадахгvйд хvрч, төсөвт хvндрэл гарч байна. Сумууд төрийн сангийн сvлжээнд холбогдон, төрийн сангаас төсвийн зарцуулалтанд тавих хяналт сайжирснаар төсвийн хэтрэлт буурч, төсвийг vр ашиггvй зарцуулах явдал багасаж байгаа нь сvвлийн вейн вйл ажиллагааны ололттой тал болж байна.

Орон нутгийн төсвийн ор 165,6 сая, авлага 55,5 сая тогрог болж оны эхнээс ор 123,3 сая тогроогоор осож, харин авлага 102,5 сая тогроогоор буурсан байна.

Улсын төсвийн байгууллагууд авбал зохих санхvvгийн дэмжлэгийг 100 хувь (17288,3 сая тогрог) авсан. Харин эрвvл мэндийн даатгалын сангаас авах санхvvжилт (1284,9 сая тогрог) 45,1 сая тогроогоор дутуу байна.

144,3 сая тогрогийн оорийн орлого хуримтлуулахаас 248,6 сая тогрогийн орлого оруулсан нь төлөвлөгөөг 104,3 сая тогроогоор давуулсан vзвvлэлт юм.

Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын төсвийн зарлага 18717,6 сая тогрог буюу төлөвлөснөөс 1104,8 сая тогроогоор бага дvнтэй гарсан нь эдийн засгийн ангиллаар хэмнэлтэй зарцуулагдсан гэсэн вг. Энэ нь төсвийн зарцуулалтанд тавих хяналт сайжирч, vргvй зардал гарах нь багассантай холбоотой. Тvвнчлэн төсвийн ор 345,9 сая тогрог болж, оны эхнээс 149,6 сая тогроогоор оссон бол авлага 60,8 сая тогрог болж, 74,6 сая тогроогоор буурчээ. Төсвийн орийг ангилан авч vзвэл БСШУ-ны сайдын харьяа байгууллагууд 200,2 сая тогрог, эрвvл мэндийн сайдын харьяа төсөвт байгууллагууд 129,2 сая, шадар сайдын харьяа төсөвт байгууллагууд 10,1 сая тогрог бусад сайдуудын багц 6,4 сая тогрогийн ортэй байна.

Зарим төсвийн байгууллагууд харилцах дансандаа монготэй байгаа боловч зайлшгvй гарах зардлыг хугацаанд нь санхvvжvүлж ор, авлагаа бууруулах арга хэмжээ авахгvй байгаадаа дvгнэлт хийх хэрэгтэй гэдгийг зовлох байна.

Санхvv Төрийн Сангийн хэлтсээс мэдээлэв

Бичсэн

2011 оны 9-р сарын 20, Мягмар гариг, 21:10

Аймгийн ЗДТГ-ын Санхvv Төрийн Сангийн хэлтэс